



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

“Монре даатгал” ХХК-д хувь нийлүүлэгчдийн
бүрэлдэхүүн, дүрмийн сангийн бүтэцдээ өөрчлөлт
оруулахыг зөвшөөрөх тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монре даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгч У.Сийлэнгийн өмчлөлийн 200 000 000 /хоёр зуун сая/ төгрөгийн бүгд 200 000 /хоёр зуун мянга/ ширхэг хувьцааг хамтран ажиллах гэрээний үндсэн дээр тус компанийн гүйцэтгэх захирал П.Ганзоригт шилжүүлсний дагуу компанийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгчдийн нэрс	Дүрмийн сангийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	Р.Туяацэцэг	261,860,000.0		261,860,000.0	26.2
2	У.Сийлэн	738,140,000.0	(200,000,000.0)	538,140,000.0	53.8
3	П.Ганзориг		200,000,000.0	200,000,000.0	20.0
	Нийт	1,000,000,000.0		1,000,000,000.0	100.0

2. Хувь нийлүүлэгчдийн бүтэцэд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн холбогдох баримтыг 2012 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Монре даатгал” ХХК /П.Ганзориг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



ДАРГА

Д. БАЯРСАЙХАН